Ёс зүйн хорооны 2025 оны ... дүгээр
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжсэнтэй холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газар нь Засгийн газрын тохируулагч агентлаг болж, статуст өөрчлөгдсөн. Тус газрын харьяа Иргэний нисэхийн үндэсний төвийн статус Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болж, чиг үүрэг салсан. Ингээд Иргэний нисэхийн ерөнхий газрын Ёс зүйн зөвлөл нь Иргэний нисэхийн ерөнхий газрын Ёс зүйн дэд хороогоор 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/19 дугаар тушаалаар 7 гишүүнтэйгээр шинэчлэн байгуулагдсан.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
Тус газрын Ёс зүйн дэд хороо нь 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөнд заасны дагуу: 1. ЗТЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаатай хамтран 2025.02.14-ний өдөр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн талаар танилцуулга, сургалтыг зохион байгуулсан. ИНЕГ-ын нийт ажилтнууд уг сургалтад танхимаар хамрагдсан. 2. Монгол Улсын Ёс зүйн хорооноос 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр цахимаар Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой сургалтыг зохион байгуулсан ба нийт ажилтнууд цахимаар хамрагдсан. 3. Төрийн албаны зөвлөлөөс 2025.11.13-14-ний өдрийн хооронд "Ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөл эрсдэлийг тооцох, зөрчлийг бууруулах, албан хаагчдын ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ хийх аргачлал" сэдэвт сургалтад ИНЕГ-ын Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг Ө.Маралмааг хамруулсан. 4. Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулж буй "Ойлгоё, энэрье" сарын аяны хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын нийт ажилтнуудыг хамруулан итгэлцэл, ойлголцол талархлаас хамтын соёл эхэлнэ уриан дор Монита арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 22-ны өдрүүдэд зохион байгуулсан. 5.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулж буй үйл ажиллагааг тогтмол дэмжиж, хамтран ажилласан. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхгүй байж, ёс зүйн манлайллыг нэн тэргүүнд үзүүлэн ажиллаж байна.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

Scanned with CamScanner

Тайлант хугацаанд нийт 7 гомдол, мэдээлэл ирүүлснээс
1. 2025.01.08-ны өдөр гаргасан СХОГ-ын ахлах мэргэжилтэн А.Энхзаяагаас ирүүлсэн өргөдлийг Ёс зүйн дэд хороо хүлээн авч, хэлэлцээд 2025.02.12-ны өдрийн 25/01 дугаартай дүгнэлтээр "Ёс зүйн зөрчилгүй" гэж үзсэн.
2.ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.22-ны өдрийн 03/1818 дугаартай албан бичгээр Ц.Мөнхсарангийн ирүүлсэн өргөдлийг хүлээн авч, хэлэлцээд 2025.05.30-ны өдрийн 25/02 дугаартай дүгнэлтээр "Ёс зүйн зөрчилгүй" гэж үзсэн.
3. 2025.09.04-ний өдөр гаргасан ААХХ-ийн иргэний нисэхийн хяналтын байцаагч П.Сүхболдоос ирүүлсэн өргөдлийг Ёс зүйн дэд хороо хүлээн авч, хэлэлцээд 2025.10.23-ны өдрийн 25/03 дугаартай дүгнэлтээр "Ёс зүйн зөрчил гаргасан" гэж үзсэн.
4. 2025.10.10-ны өдөр НСГ-ын иргэний нисэхийн хяналтын байцаагч Х.Оргилцэцэгээс ирүүлсэн гомдлыг хүлээн авч, хэлэлцээд 2025.11.06-ны өдрийн 25/04 дугаар дүгнэлтээр "Ёс зүйн зөрчилгүй" гэж үзсэн.
5. 2025.10.15-ны өдөр ГХАГ-ын мэргэжилтнүүдээс ирүүлсэн гомдлыг хүлээн авч, хэлэлцээд 2025.11.19-ний өдрийн 25/05 дугаар дүгнэлтээр "Ёс зүйн зөрчилтэй" гэж үзсэн.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн ойлголт, ёс зүйн нийтлэг хэм хэмжээ гэж юуг хэлэх вэ, хэм хэмжээг зөрчсөн бол ямар хариуцлага хүлээх вэ гэх мэт хуулийн талаарх мэдлэг дээшилсэн.	1. Дотоод зохион байгуулалтын нэгжийн даргатай холбоотой гомдолд тухайн нэгжийн ажилтан Ёс зүйн дэд хорооны гишүүнд ажиллаж байгаа учир ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхын тулд гомдол хэлэлцэх хуралд оролцохгүй байх, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэхэд өөр бусад гишүүдэд хуваарилах зэрэг хүндрэлүүд гарсан. 2. Ёс зүйн зөрчлийг тогтооход нотлох баримт хангалтгүй, гомдол гаргагч, гомдолд холбогдогч нарын амаар тайлбар авах нь дүгнэлт хийхэд хүндрэлтэй, гэрчээс мэдүүлэг авах гэхээр тайлбар өгөхөөс татгалзах зэрэг хүндрэлүүд гарсаар байна. 3.

Санал:

1. Ёс зүйн дэд хорооны гишүүд нь байгууллагын нийт ажилтнуудын дийлэнх олонхийн саналаар томилогдсон бөгөөд гишүүд нь өөрийн дотоод итгэл, үнэмшил, ёс зүйтэй байдлаараа бусдаас ялгарсан учир зарим нэг тохиолдлуудад өөрийн дотоод итгэл, үнэмшлээр дүгнэлтээ өгөх эрхийг хууль тогтоомжид тусгах, заавал нотлох баримт шаардахгүйгээр шийдвэрлэх боломжийг олгох зохицуулалтыг хууль болон журамд тусгах.
2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-д заасныг зөрчсөн л бол гомдлыг хэлэлцэж, дүгнэлт гаргана гэх зохицуулалт нь учир дутагдалтай байгаа учир мөн хуулийн 7 дугаар зүйлд заасан Ёс зүйн нийтлэг хэм хэмжээг зөрчсөн бол ... гэж хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулах.
3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээлгэхдээ Төрийн албанаас халах хүртэл арга хэмжээ авах зохицуулалт нь зарим төрийн байгууллагын ажилтан, албан хаагч нарт авах арга хэмжээнээс өөрөөр зохицуулагдсан байгаа учир энэ хэсгийг Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна гэж хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналтай байна.

Шалгах хэсэг:

☑ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

Scanned with CamScanner

☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан
Иргэний нисэхийн ерөнхий газрын
дарга Э.Төрбаяр

Ёс зүйн дэд хорооны дарга Г.Мөнхболд

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн
Дарга Ө.Маралмаа

Огноо: 2025 оны 12 сарын 25

Scanned with CamScanner

Ёс зүйн хорооны 2025 оны ... дугаар
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлагдсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	10
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0,5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0,5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0	0
Хэсгийн оноо				**4**	3	30
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	3	30
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	3	10
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**9**	**70**

Нийт 90

БАТЛАВ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА
Г.МӨНХБОЛД

2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв (сая. төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2024 он)	Зорилтот түвшин	Хугацаа Улирал (I-IV)	Хариуцах эзэн
ЗОРИЛТ 1. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР								
1.	1.1.	Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах.	-	Төлөвлөгөөг батлуулсан эсэх Хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөний төслийг боловсруулж байна.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** 2025 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг 50 хувьд хүргэнэ. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувьд хүргэнэ.	I-IV улирал	Нарийн бичиг, Гишүүд
2.	1.2.	Ёс зүйн хороонд “ИНЕГ-ын ёс зүйн дэд хороо”-ны бүрэлдэхүүнийг бүртгүүлж, ёс зүйн дэд хорооны дүгнэлтийн батлагдсан хэвлэмэл хуудсын загварыг авч, хэвлүүлэх.	-	Хэвлэмэл хуудсыг хэвлүүлсэн эсэх	-	**I улиралд** Хэвлэмэл хуудсыг батлагдсан загварын дагуу хэвлүүлсэн байна.	I улирал	Нарийн бичиг

3.	1.3.	Ажилтнуудад төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах.	-	Зохион байгуулсан сургалтын тоо	-	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** 1. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** 1.	I-IV улирал	Гишүүд
4.	1.4.	Шинээр ажилд орсон ажилтнуудад ёс зүйн асуудлаар мэдээлэл өгөхөд холбогдох нэгжтэй хамтран ажиллах.	-	Мэдээлэл өгсөн ажилтнуудын тоо	-	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Гүйцэтгэлээр **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** Гүйцэтгэлээр	I-IV Улирал	Гишүүд
5.	1.5.	Хамт олны хамтач, бүтээлч, найрсаг уур амьсгалыг бүрдүүлэх, зорилгоор ажил олгогчтой хамтран ажилтнуудын дунд спортын арга хэмжээ зохион байгуулж	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** 1	I-II улирал	Гишүүд
6.	1.6.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг шалгаж, дүгнэлт гаргах.	-	Дүгнэлтийн тоо	2024 оны гомдол мэдээллийг цахимаар тогтмол хүргүүлж байсан.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Гүйцэтгэлээр **Жилийн эцсийн байдлаар**: **III-IV улиралд:** Гүйцэтгэлээр	I-IV улирал	Гишүүд
7.	1.7.	Нэгжүүдэд ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх.	-	Зөвлөмжийн тоо	-	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Гүйцэтгэлээр **Жилийн эцсийн байдлаар**: **III-IV улиралд:** Гүйцэтгэлээр	I-IV улирал	Гишүүд
8.	1.8.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын	-	Тайлангийн тоо		**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:**	I-IV улирал	Нарийн бичиг

		тайлан, мэдээг гаргаж Ёс зүйн хороонд хүргүүлэх.				1 **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** 1		
9.	1.9.	Байгууллагын цахим хуудсанд дэд хорооны мэдээллийг байршуулах.	-	Байршуулсан мэдээллийн тоо	-	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Гүйцэтгэлээр **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** Гүйцэтгэлээр	I-IV улирал	Нарийн бичиг
10.	1.10	Урьдчилан сэргийлэх, соён гэрээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар явуулах.	-	Арга хэмжээний тоо	-	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** 1 **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** 1	I-IV улирал	Гишүүд

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.АМАРБАЯСГАЛАН